

II. МОНГОЛЫН ОЙРХИ ТҮҮХИЙН АСУУДЛУУД

1914 ОНД МОНГОЛД ПАРЛАМЕНТЫН ЗАСАГЛАЛЫН ЭХ ТАВИГДСАН НЬ АРДЧИЛАЛЫН ЭХЛЭЛ БАЙВ УУ

С.Отгонжаргал

Монгол улсын их сургууль. Нийгмийн шинжлэх ухааны сургууль. Түүхийн тэнхим

Өгүүллийн товч утга: Монгол улсын түүхэнд 1911 оны ҮЭЧХ- ний дараа феодализм тэр чигээрээ үлдэж улс төр, эдийн засаг, нийгмийн амьдралд шинэчлэлт хийгдсэнгүй зарим нэгэн амиа аргацаасан арга хэмжээ авч байсан гэсэн ойлголтыг өөрчилж түүхэн үнэнд ойртуулах, ялангуяа Монголд хэмжээгүй эрхт хааны дэргэд зөвлөх эрхтэй дээд доод хурал байгуулагдсан явдал нь парламентийн буюу ардчиллын эхлэл байсан уу гэсэн асуудлыг тодруулах цаг болжээ гэж үзэж байгаагаа илэрхийлэхийг зорьсон болно.

Түлхүүр үг: 1911 он, тусгаар тогтнол, 12 сарын 29, дээд доод хурал, парламент, ардчилал.

1911-1912 оны ҮЭЧХ-ний үр дүнд Монголын ард түмэн Манжийн 200 гаруй жилийн дарлалыг устгаж, өлзий учрал бүрдсэн өдөр хэмээн бэлэгшээж, Монголын цагагчин гахай жилийн өвлийн дунд сарын шинийн есөн буюу Европын 1911 оны XII сарын 29-ний өдрийг сонгон тохиолдуулж Богд Жавзандамба хутагтаа хэмжээгүй эрхт эзэн хаанаар өргөмжлөн оны цолыг олноо өргөгдсөнөөр тунхаглаж, МУ-ын Засгийн газрыг Дотоод, Гадаад, Цэргийн, Сангийн, Шүүх зэрэг таван яамтайгаар байгуулсан байна.

Үндэснийхээ тусгаар тогтнолыг сэргээн мандуулсан Богд хаант Монгол улсын төр, засгийн газар Дундад иргэн улс, Хаант Орос улс, АНУ, Япон, Англи, Франц, Герман, Дани, Голланд, Бельги, Австри зэрэг дэлхийн томоохон улсуудад хандаж тэдгээрээр уламжлан дэлхий дахинд тусгаар тогтнолоо зарлан тунхаглажээ. Чухам энэ үеэс Хаант Орос улсаас Монголд суугаа консулын үйл ажиллагаа улам идэвхжиж Монгол улсын дотоод, гадаад бодлого, үйл ажиллагаанд өргөнөөр оролцох болсон юм. АНУ-д илгээсэн Монгол Улсын нот бичигт “Монголын эзэнт улсын Гадаад хэргийн яам Олноо өргөгдсөний хоёрдугаар оны 10-р сарын 9-ний өдөр АНУ-ын Гадаад хэргийн яаманд: Бидний монголчууд газар нутаг, шашин суртал, ёс журмаа хадгалах зорилгоор Чин улсаас салж бүрэн эрхт тусгаар тогтносон улсыг байгуулав. Монголын шарын шашны тэргүүн Жавзандамба хутагтыг төр, шашны хэргийг мандуулахаар Монголын эзэн хаанд өргөмжилж, Олноо өргөгдсөний тэргүүн цол хүртээв. Энэхүү мэдээллийг гадаад орнуудын засгийн газарт хүргэхийг хичээнгүйлэн хүснэ. Бусад засгийн газарт энэхүү мэдээллийг хүргэхээс гадна үүнийг хүлээн авмагц таныг засгийн газраасаа биднийг хүлээн зөвшөөрч, гэрээ байгуулан, найрамдлыг зузаатган худалдаа хийх хүсэлтийг уламжлахыг хүснэ.” Монголын Засгийн газрын энэхүү нот бичигт АНУ хариу өгөөгүй боловч Харбин дахь консулын газар нь (Консул Мейнард) Төрийн Департаментдаа тухайн үед хүргүүлжээ. Оросын нөлөөнд Ар Монгол орж тус хоёр орон найрамдлын хэлэлцээр байгуулсанд эмзэглэж байсан Хятадын засгийн газарт нот хүлээн авсан тухай мэдэгдээгүй нь нааштай хандлага байв. АНУ уг нот бичгийг буцаагаагүй зэргээс үзэхэд Богд хаант Монгол Улс, АНУ хоёр албан ёсоор харилцаанд анхлан орсон гэж үзүүштэй” (1.63) хэмээсэн доктор Р.Болдын саналыг бичигч талархан үзэж байгаа юм.

АНУ Богд хаант Монгол улстай Дундад иргэн улсад сууж буй элчин сайдаараа дамжуулан харилцаж, улмаар Монголд худалдааны үйл ажиллагаагаа ихээхэн идэвхжүүлэх болсон байна. Япон улс ч АНУ-ын нэгэн адил Монголд улс төр, эдийн

II. МОНГОЛЫН ОЙРХИ ТҮҮХИЙН АСУУДЛУУД

засгийн талаар үзүүлэх нөлөөллийн бодлогоо хэрэгжүүлэх талаар чармайлт гаргаж байсан түүхэн баримтууд эдүүгээ үлджээ. Японы эрх мэдэл бүхий хүмүүс худалдаа арилжаа хөгжүүлэх, Монголтой хамтран ажиллах эрмэлзлэлийн дор Нийслэл хүрээнд нэг бус удаа хүрэлцэн ирж Монгол Улсын Засгийн газрын нөлөө бүхий хүмүүстэй ил, далд хэлбэрээр уулзаж, бодлого солилцох ажил ихээхэн гүнзгийрэх хандлагыг олсон байна. Монгол Улсын Засгийн газар ч АНУ, Япон улстай харилцаа тогтоох явдлыг Монгол Улсын тусгаар тогтнолын чухал нэгэн үндэс хэмээн үзэж байв. Энэ ч утгаараа Дотоод яамны сайд да лам Цэрэннимэдийг Японтой гэрээ хэлэлцээр байгуулах даалгавартайгаар Япон руу явуулсан хэдий ч Оросын хүчтэй шахалттай тулгарч Хайлаар хүрээд эргэн нутаг буцсан байна. Хайларт байсан Японы консул Монголын төлөөлөгч ирж буй тухай тодорхой мэдэж байсан хэдий ч “энэ тухай бид мэдээгүй, энэ үндэслэлгүй зүйл” хэмээн нууцалж байснаас үзээд Японы тал Монголтой холбоо тогтоох хүсэлтэй байсан нь тодорхой харагдаж байлаа юм. Да ламын Японтой хийх хэлэлцээр нь Өвөр монголыг Монголдоо нэгтгэх, эс чадваас Хятадын эзэрхийллээс гаргаж, Японы хамгаалалтанд тодорхой нөхцөлтэйгээр оруулах явдал байсан юм. Үүнээс үзэхэд 1911 онд тогтсон Монголын төр үндэс угсаа нгт Өвөр монголчуудаа нэгтгэж хүчирхэг Монгол улсыг байгуулах эс бөгөөс Монгол улсынхаа тусгаар тогтнолыг Японоор хамгаалуулах болзолтойгоор Өвөр монголыг тодорхой хугацаагаар түүний мэдэлд өгөх бодлогыг барьж байжээ. Хятад улс 1897 онд Британий хаант улстай хэлэлцээр хийж буцааж авах нөхцөлтэйгээр Хонг Конгийг 100 жилийн хугацаагаар түүний мэдэлд өгсөн түүхийг монголчууд сайтар мэдэж байсан нь үүээс тодорхой харагдана. Энэ бодлого нь Богд хаант Монгол улсын гадаад бодлогын гайтамшгийг илэрхийлсэн үйлдэл байлаа.

Ийнхү Монгол Улс хүн төрөлхтний жам ёсны урсгалаар хөгжих хэтийн чигийг баримжаалах болов. Эдийн засгийн салбарт зах зээлийн эдийн засгийн бодлогыг баримжаалж, гадаадын капиталыг аль болох түлхүү оруулах болсоноор Монголд гадныхны үйл ажиллагаа эрс идэвхижжээ. Орос, Франц, Хятадын хөрөнгөтнүүдийн хувь нийлүүлсэн “Монголоор” алтны уурхай үйл ажиллагаагаа улам тэлж хорь шахам салбартайгаар ажиллах болов. Богд хаант засгийн газраас оросын хөрөнгөтнүүдэд “Монгол үндэний банк” нээх эрх олгов. Мөн Англи, АНУ, Герман, Франц, Бельги, Дани, Чех, Норвеги Турк зэрэг европын олон орны худалдааны хүмүүс, үйлдвэрийн эздийн Монгол оронд уурхай, үйлдвэр нээх, хөрөнгө оруулах саналыг Засгийн газар дэмжиж байв. Энэ бодлогын үр дүнд Хүрээнд Австрийн “Генрих”, Наймаа хотод Норвегийн “Мамия”, зэрг гадаадын олон пүүс ажиллах болж Грекийн иргэн Ф.Корифиди, талх чихэр, бурам үйлдвэрлэх газар, Австрийн иргэн В.Ф.Генрих архи пивоны завод, Германы иргэн Хакмаг Америкийн бараа таваар худалдаалах дэлгүүр зэрэг жижиг үйлдвэрүүд, худалдааны гзруудыг ажиллуулах болжээ. Ингэж Монгол Улс хөрөнгөлөг замаар хөгжих эхлэл 1911 оны ҮЭЧХ-ний дараа тавигджээ. (2.176-177)

Ийнхү хөрөнгөлөг замаар улс орноо хөгжүүлэх болсон нь засаглалын хэлбэрийг өөрчлөхийг зй ёсоор шаардах болов. Дэлхийн олон оронд төрийн хэргийг шийдэхэд ард түмний саналыг төлөөлөгчдийн байгууллагаар дамжуулан авах парламентын ёс нэгэнт тогтсоныг Монголын Засгийн газар хэлэлцэн үзэж үндсэн хуульт засаглалыг тогтоож Улсын хурлы байгуулах нь зүйтэй хэмээн үзжээ. Энэ үеэс дэлхийн хөгжингүй орнуудын үндсэн хуулийг орчуулан судлах ажил эрчимтэй өрнөжээ. Энэ тухай эрдэмтэн З.Лонжид “1924 оноос мнө гадаадын хэдэн улсын үндсэн хуулийг монгол хэлнээ орчуулсан бэ?” илтгэлдээ “...1910-аад онд гадаадын хэд хэдэн улсын үндсэн хуулийг бүрнээр нь буюу хэсэгчлэн орчуулсан бололтой. Гэтэл зарим судлаачид (нэрсийг нь зориуд эс дурдав. З.Л) 1920-иод оноос өмнө эрх зүйн томоохон хэд хэдэн бүтээлийг орчуулах чадвартай хүн Монголд байгаагүй учраас тийм орчуулга байх боломжгүй гэж үгүйсгэдгийг хэрхэвч зөвшөөрөх аргагүй. ... Миний үзсэнээр бол АНУ, Англи, ЗОУ, Норвеги, Японы үндсэн хуулиудын очуулга гар бичмэлээрээ ҮТНС-д хадгалагдаж байна” (3.154) гэсэнтэй бичигч бүрэндүүрэн санал нэгтэй байгаа юм. Эрдэмтэн С.Идшинноров Монгол Улсын

Үндсэн хуулийн хоёр төслийн тухай өгүүлэлдээ "... Хаант Монгол Улсын Ерөнхий сайд Т.Намнансүрэн буриад эрдэмтэн Ж.Цэвээнд даалгавар өгч Улсын хурлын гишүүдийн эрх, үүрэг, эзэн хаан, Засгийн газар, Улсын хурлын хоорондын харилцааны учир холбогдлыг гадаад орнуудын жишээн дээр тайлбарласан "Улсын эрх" хэмээх номыг бичүүлж байсан нь санамсаргүй зүйл огт биш байжээ" (4. 93) гэсэн нь үндсэн хуульт засаглалыг тогтооход нилээд ул суурьтай хандаж олон орны үндсэн хуулиудыг судлаж байсан гэсэн эрдэмтэн З.Лонжидын дүгнэлттэй тохирч байгаа юм. Үүнээс үзэхэд Улсын хурлыг байгуулах асуудал 1911 онд тавигдан 1914 он хүртэл бэлтгэл ажил хийгдэж олон орны үндсэн хуулийг орчуулж судлажээ гэж үзмээр байна. Ийнхүү бэлтгэл ажил хангагдсанаар 1914 онд Богд хааны Засгийн газрын дэргэд зөвлөх эрх бүхий Улсын дээд, доод хурлыг байгуулжээ. Өгүүллийг бичигч 2002 онд Английн Кэмбрижийн Их сургуульд XX зууны Монголын түүхээр цуврал лекц унших явцад хаанд зөвлөх эрх бүхий дээд, доод танхимтай хурлыг байгуулсан талаар ярихад Английн эрдэмтдийн анхаарлыг ихэд татсан юм. Монгол Улсыг Англи лугаа засаглалыг хэрхэн тогтоосон талаар сонирхон асууж байлаа. Тэдний асуултанд хоцрогдсон, бөглүү Монгол Улс Англи дахь засаглалын талаар мэдэх боломжгүй гэсэн өнгө аяс илт мэдрэгдэж байсан нь гадныханд ийм ойлголтыг гүн бат суулгасан буруу нь түүхчид бидэнд ноогдох учиртай хэмээн бодож билээ. Олон орны хуулиудыг судлах явцад Англи, Японы хууль Монголчуудын хаант засаглалаа авч үлдэх хүсэл эрмэлзэлтэй нь яв цав нийцэж байснаар эдгээр орнуудын хуулийг нарийвчлан нягтлан үзэж үлгэр болгосон гэлтэй байдаг. 1924 оны Үндсэн хуулийг боловсруулах бэлтгэл ажил ид өрнөж байх явцад хуралдсан "1922 оны IX сарын 1-ний өдрийн АЗГ-ын 39-р хурлын тогтоолын нэгдүгээр зүйлд "хууль зүйлийг зохион байгуулах хэргийг нэн яаравчилваас зохино... Үндсэн Хуулийг ардын эрхт хэмжээт цаазат **Англи мэт улсын хуулиас товчлон авч** эдүгээгийн явуулан буй засгийн байдалд нийцүүлэн зохиовоос зохино. ... шүүх таслах хуулийг Европын хууль лугаа харьцуулан мөн эдүүгээх явуулж бүхий дүрэм хэмжээнд нийлүүлэн засаж залруулан дахин гурван сарын хугацааны дотор нэн идэвхийлж зохиолгон дараа дараагаар засгийн газраа мэдүүлэн хянан тогтоолгох явдлыг засгийн газраас харьяат комиссын сайд түшмэдэд хойш ухуулан тушааж гүйцэтгэхээр тогтов" (5.30) гэсэн нь дээрхи санааг батлаж байгаа юм. Энд Англи мэт улсын хуулиас товчлон авч гэснийг үзэхэд Англи улсын хууль бэлэн орчуулагдсан байсан нь илэрхий мэт. Нөгөө талаар Англи улсын хуулийг цохон заасан нь 1914 онд хаант засагтай хурлыг байгуулж байсан туршлагыг залгамж холбоонд нь суурилуулан 1924 онд сэргээх зорилготой байсан гэлтэй санагдана.

1914 оны III сарын 23-ны өдөр "Богд хаанаас Улсын Дээд, Доод Хурлын газрыг нээх зарлиг гуйсан бичиг" гарч түүнд "Улс төрийн хүнд чухал хэргийг нийлэн хэлэлцэх Хурал нээн шийтгэвээс болох ба үл болохыг заалхийлэн сургахыг гуйж, эл зүйл дор дүрэм хэмжээ найман зүйлийг төлөвлөн тогтоож айлтгах нугалбарын эх ... сайд түшмэл болсон шавь боолчууд эзний өршөөл хишигт хувь илүү сүслэн шүтэж аливаа улс төрийн бүхий л хэрэгт эрх үгүй хэрэг бүр санаа эрж шүүмжлэн хэлэлцэж санаа бодлыг нэгтгэн улсын хүчин чийрэг бат, эдийн засаг элбэг дэлбэг, хүн бүр хүрэлцэхээр бүр баян талбиу, дотоодод ариун тодорхой, гадаадад найртай түвшин болох явдлыг өдөр бүр эрмэлзэн цаг бүр чармайн шийтгэвээс зохимой.

Үүнд дэлхий дахины олон хүчирхэг бөгөөд, баян боловсорсон улс цөм улсын хурал нээн шийтгэж, төлөөнөө хүн гаргаж дээд хуралд улс төрийн ашиг зовлонг хэлэлцэх ба, доод хуралд газар оронд тус бүхий үгүйн их төлөвийг тайлбарлан хэлэлцэхэд тус тус тэргүүн байгуулж нийтийн бодлого нэгтгэснээс бүх хүчнийг олжихуй.

Манай улс хурлын тэргүүн төлөөний хүнийг энэ удаа сонгон гаргасан үгүй хэмээвч харьяат сайд түшмэд нийтээр газар орны байдлын төлөвийг төсөвлөн мэдэж чадахын тул, зүй нь урьдаар Улсын Дээд, Доод хэмээх хурлыг үүсгэн шийтгэсүгэй" (6. 24) гэснээс үзвэл Улсын дээд, доод хурлыг байгуулах хүсэлтийг 1914 оны III сарын 23-ны өдөр гаргасныг IV сарын 12-ны өдөр Богд хаан зөвшөөрсөн байна. Нөгөө талаар уг гуйсан бичигт "энэ

II. МОНГОЛЫН ОЙРХИ ТҮҮХИЙН АСУУДЛУУД

удаа сонгон гаргасан үгүй хэмээвч” гэснээс үзэхэд хэсэг хугацааны дараа төлөөний хүнийг сонгуулийн журмаар томилох санаа оноо давхар явж байжээ гэмээр байна. Богд хааны зарлигт “Дээд хуралд бүгд ерөнхийлөн захирах зэрэг олон яамны тэргүүн ба эрхэлж зөвлөх, дэд сайдууд, жич Нийслэлд бүхий засаг ба засаг бус олон хан, ван, бэйл, бэйс, гүн засгууд, их шавь ба Хөлөн буйр, Дарьганга, Цахрын зэрэг газрын бүгдийн дарга нарыг бүрнээ хуралдуулан шийтгүүлсүгэй” (6. 28) гэснээс харахад Өвөр монголыг нэгтгэсэн хүчирхэг Монгол Улсыг байгуулах Засгийн газрын бодлого тодорхой харагдаж байна. “Доод хуралд мөнхүү олон яамны дэс түшмэл, эх зохиох түшмэл нар ба, басхүү Нийслэл хүрээний Эрдэнэ шанзудбын яам, дөрвөн аймгийн да жанжин, суурин жасаадаас нижгээд түшмэлүүдийг бүрнээ хуралдуулан хэлэлцүүлсүгэй. Бас ч олон яамны дэс түшмэл, эх зохиох түшмэлийн дотор засаг ба засаг бус ван, бэйл, бэйс, гүнгүүд буй аваас Доод хуралд хуралдуулахыг хэрэгсэх үгүй, өөр өөрийн хэргэм зэрэг дэвээр Дээд хуралд хуралдуулсугай” (6.28) гэснээс Дээд хуралд угсаа залгамжилсан язгууртнууд дэс түшмэл байхаас үл хамааран язгуур угсаагаараа суух эрхийг олгосон байна. Энэ бүгдээс үзэхэд Английн Дээд, Доод танхимын зарчмыг баримталсан байгаа нь тодорхой харагдаж байна.

Ийнхүү Богд хаант Монгол Улс парламентын засаглалтай болсоноор ардчиллын эхлэл XX зуны эхэн үед тавигджээ гэж үзэх бүрэн боломж байгаа юм. Парламентын засаглалд шилжсэнээр Монгол Улс эрчимтэй хөгжих замд эргэлт буцалтгүй орсон байна. 1916 онд гүн Бадрахбаатар улсын хөрөнгөөр Монголын үндэсний банк байгуулах тухай саналыг Доод хуралд хэлэлцүүлэхээр оруулж байжээ. Тэрээр “Монголын бүх малыг 16 сая гэж тооцоолон бод мал бүрээс тавин мөнгө, жижиг мал бүрээс арван мөнгөний татвар татаж, цугларсан гурван сая лангаар банкны үндсэн фондыг байгуулах саналыг тавьжээ. Доод хурал энэхүү саналыг дэмжин малын тоог жинхэнэ үнэн зөвөөр гаргаж хүн амын нарийн тоо бүртгэлийг явуулах саналыг Дээд хуралд өргөж байжээ.” (7. 109) Мөн 1915 онд Түшээт хан аймгийн мээрэн Дорж (Ардын засгийн үед Сангийн сайд байсан) Хүрээ ба аймгуудын хоорондох өртөөний албыг автомашины харилцаагаар сольж нээх тухай саналыг Доод хуралд оруулжээ. Халх дөрвөн аймгийн өртөөний бүх зардал 880 мянган лан болж байгааг тэмдэглээд уг зардлыг бүх аймгаас бие мөнгөөр нь гаргуулах саналыг тавьжээ. Доржийн саналаар Богд гэгээний шавьд өртөөний алба оногдуулж 150 мянган ланг нэмэн татварлаж, бүх зардлыг нэг сая лан хүртэл нэмэгдүүлээд улмаар тэр мөнгөөрөө машинуудыг 3-4 жилийн дотор хэрэглэх запас хэрэгслийн хамт худалдан авах ба мэргэжил бүхий орос жолооч, техникч нарыг урих ёстой байжээ. Дорж нь техникийн ийм баазын үндсэн дээр морин өртөөг устган, автомашины харилцаанд шилжиж болно гэж үзжээ. Уг төлөвлөгөөний дотор машин гараж болон замыг цаснаас хамгаалах далан барьж байгуулах, хүмүүс ба ачааг тээвэрлэх хөлсийг тогтоох тухай ч төлөвлөсөн байв. (7.109) 1914 онд түшмэл Дандаагаас зоос цутгах, банк байгуулах, худалдаа, тариалан, барилга, тээвэр хөгжүүлэх, ашигт малтмал, ой модыг зохистой ашиглах тухай бичгийг өргөн барьж байжээ. Үүнд “зоос хэмээгч оны цолоор хамаг худалдаа арилжааг харилцан нэвтрүүлж хотол улсын амьдрах ёсонд үлэмж тус болох улсын эрдэм мөн тулд аливаа улсын чухал хэрэг мөн тул, нэгэн зоос цутгах хороо байгуулаад мөнгөн төгрөг ба зэс зоос ба гуйлан зоос тэргүүтнийг ёсчлон цутгаж дэлхий дахинд тарааж улсын эрдэнийг илэрхийлэвээс зохимой. Мөн олон хошууны аливаа алт мөнгө зэс гууль, эрдэнийн чулуу, усан болор, чулуун нүүрс тэргүүтэн гарах уулыг байцааж гадаад улсад өгөх үгүй монголчуудын олон баян ардыг хөхүүлж өртөг гарган үүнийг мөнхүү оньст хүрдний сав зэвсгээр үйлдүүлэх болвоос уулын ашиг их л бадрах болмой. (7.33-34)

Монгол Улсын хааны дэргэд байгуулагдсан Дээд, Доод хурал буюу парламентат засаглал нь 1914 онд хүчин төгөлдөр болж байсан бол 1919 оны 11-р сард Сүй Шү Жаны түрэмгийллээр аргагүйн эрхэнд хаагдсан байна. Зөвхөн УТА-д хадгалагдаж буй баримтаас үзэхэд Улсын Доод хурал нийт 65 удаа хуралдаж улс орны гадаад харилцаа, эдийн засаг, санхүү, цэрэг, соёл боловсрол зэрэг бүхий л асуудлыг хэлэлцэн Дээд хуралд уламжилж байжээ. Улсын Дээд хурал бүгд 83 удаа хуралджээ. Гэхдээ эдгээр нь бүрэн бус тоо бөгөөд

1914-1919 онд Улсын хурлаар хэлэлцсэн асуудлыг тусгасан баримт үлдэж хоцроогүй байна. (6.18) 1919 оны 7-р сард Монголын автономит засгийг цуцлах, эсэх асуудлыг Улсын хурлаар хэлэлцжээ. Улсын Доод хурал автономит засгийг сайн дураар устган Хятадын хараат болохыг эсэргүүцэж, харин Дээд хурал түүнийг устгахыг зөвшөөрсөн шийдвэр гаргажээ. (6.12) Энэ хоёр шийдвэрийн талаар судлаачид өөр өөрийн саналыг дэвшүүлсээр ирсэн бөгөөд голдуу Дээд хурлыг буруутгах хандлага давамгайлсаар иржээ. Ийм ч учраас тухайн үед Дээд хурал чухам яагаад тусгаар тогтнолоо устгах шийдвэр гаргасныг дахин нягтлан үзэх шаардлага байсаар байгаа юм. Энэхүү түүхэн үйл явцад биеэр оролцож явсан Н.Магсаржав хожим нь “Монгол Улсын шинэ түүх” номоо 1925-1927 онд бичиж үлдээжээ. Н.Магсаржав нь Богд хааны монгол бичгийн багш, Дотоод хэргийн яамны эх зохиогчоор ажиллаж байсан хийгээд 1922 оны эцэс хүртэл Ардын засгийн Шүүх яамны анхны сайдаар ажиллаж байжээ. “Монгол улсын шинэ түүх” номондоо “Автономит засгийн газраа устгах явдлыг хүчээр тулгасанд ... засгийн газрын Дээд, Доод хурлын гишүүдийг зарлаж харъяат хоёр хурлыг нийлж хуралдуулан тэргүүн сайд хичээнгүй гүн Цэрэндоржоос ам нээж, Хятад сайд Чин И-гээс автономит засгийг устгаж Дундад иргэн улсад нэгтгэн захируулахаар сэдэвлэсэн хэргийн учрыг илтгэсэн тухайд Дээд хурлын олон ван, гүнгүүдээс их л зөвшөөрмөөр байсан нь нэг бол өөрсдийн эрх ашиг хэвээр тогтох, хоёрт болбоос Хятад лугаа ичнээ хуйвалдаж нийлэхийг дурласан ... баймаар буй. Гагцхүү энэ хэргийг Доод хурлаас нилээд эсэргүүцэж их төлөвийн байдлыг дараа боловсрон зөвлөлдөж мэдүүлэхээс бус энэ удаа ашиг жорыг шүүмжилж гүйцэх үгүй хэмээн хэлэлцэж тархсан ажгуй” (8. 155) хэмээснээс үзвэл Дээд, Доод танхимыг нэгтгэн хуралдуулсан нь уг асуудалд нилээд ач холбогдол өгч байсныг тодорхой харуулж байна. Хэрэв үнэхээр дээдэс хуйвалдан тусгаар тогтнолоо худалдахаар тохирсон байсан бол Доод хурлын гишүүдийг оролцуулахгүйгээр хуралдах боломж нь Дээд хуралд хуулиар олгогдсон байсныг анхааран үзэх хэрэгтэй. Н.Магсаржавын номон дахь бас нэг анхаарал татаж байгаа мэдээлэл бол автономитыг устгах асуудлыг Бээжин хэрхэн үзэж байсан талаар тодруулах зорилгоор Богд хаан төлөөлөгчөө томилон илгээж байжээ. Энэ тухай “Их Зунтанд (ерөнхийлөгч С.О) илгээх нууц захидал бичүүлж мөнхүү дайчин жонон вангийн хошууны гүн Гомбыг Бээжин дор зарж явуулсан хэрд гүн Гомбоос уг хэргийг нэвтрүүлж чадахгүй тулгамдаж ихээхэн лам ноёдын нэгийг ирүүлтүгэй хэмээн цахилгаанаар хойш мэдэгдсэн тухайд Богд хаанаас жалханз хутагт Дамдинбазарыг томилон илгээсэн билээ. Харъяат хутагтын бие их Зунтанд нүүр учирч тухайтай хэргийн байдлыг илтгэсэнд энэ хэргийг яарах явдалгүй хутагтын тааллаар автономит засгийн эрхийг хэвээр хадгалж болмой хэмээхийг сонсоод хэрэг бүтэв хэмээн баярлаж байсан ...” хэмээжээ. Эндээс үзэхүл Дээд хурал ямар нэгэн зөрчилгүйгээр дипломат аргаар тусгаар тогтнолоо авч үлдэх арга замыг сүвэгчилж байжээ гэмээр байгаа юм. Гэвч харамсалтай нь эл асуудлыг ийнхүү шийдэж байх агшинд Чин И-гийн хажуугаар Сюй Шү Жан Японы түлхээсээр цэргийн сүр үзүүлэн автономитыг устгажээ. Энэ үйлдлийг Богд хааны засгийн газар хэрхэн үзэж байсныг Н.Магсаржав “Богд хаанаас энэ нэгэн удаа Хятадын эрх мэдэлд оровч хоёр гурван жилээс өнгөрөхгүй дахиж эрхээ олж авах цаг хүрч ирэх тул барцас ёсоор болгогтун хэмээснээр ерөнхий сайд Бадамдорж Сюй Шү Жанд биеэр уулзаж автономит засгийн эрхийг устгах явдлыг Богд хаан зөвшөөрч айлдсан хэмээн хэлсэнд тэнд жагсаасан цэргийг татсан буй” (8.157) гэжээ. Үүний дараа Дээд, Доод хурал дахин хуралдаж Дээд хурал зөвшөөрсөн хийгээд, Доод хурал бас л эсэргүүцэн хүлээж авчээ. Үүнээс үзэхэд Богд хаант засгийн газрын Дээд хурал нилээд алсын хараатай шийдвэрийг гаргаж байжээ гэж үзүүштэй байгаа юм. **Сюй Шү Жаны олон мянган цэргийн эсрэг Богд хаант засгийн газар хүч мөхөсдөхөө тооцоолж цөөхөн монголчуудынхаа цусыг урсгахгүй байх, эв эээр тусгаар тогтнолоо эргүүлэн тогтоож болно хэмээн үзэж байсан нь Богд хааны хэлж байсан ердөө хоёр гурван жилийн асуудал юм хэмээн тооцсоноос тодорхой харагдаж байна.** Ингэж бодох үндэслэл нь юуны түрүүнд жалханз хутагт Дамдинбазарыг Бээжинд илгээж авсан шийдвэр, нөгөө талаас Сюй Шү Жан Хятадын бус

II. МОНГОЛЫН ОЙРХИ ТҮҮХИЙН АСУУДЛУУД

өөр орны гар хөл болж байсныг тооцож Япон улстай дипломат аргаар асуудлыг нааштай шийдвэрлэж болно хэмээн үзэж байсантай холбоотой болов уу. Доод хурлын гишүүдэд энэ санаагаа бүрэн илэрхийлэх боломжгүй байснаас Доод хурлын гишүүд хувьсгалт үйл ажиллагаанд идэвхийлэн орсон байдаг. Ингэж Дээд хурлын алсын хараатай бодлогыг Доод хурлын гишүүд бүрэн ойлгоогүйгээс түүхэн үйл явц буруу голдирог луу орж хаанаа буудан алсан улаан Оросоос цэрэг зэвсгийн тусламж авах алхам хийгдсэн байна. Энэ тухай “МАХН-ын түүхэнд холбогдол бүхий зүйлүүд” номонд Д.Догсомын дурсан бичсэнээс тодорхой харагддаг. “Энэ тухай хэрхэвээс зохихыг хэлэлцсүгэй хэмээн бачимдуулан шаардсанд Доод хурлаас Иргэн улсад дахин дагаар орвоос, харъяат Монголд тустай газар огт үгүй, харин ч зүйл зүйлийн зовлон зүдгүүрт холбогдох хортой, харшлалтай явдал нэн үлэмж болох учрыг тайлбарлан гаргаж ... энэ явдлыг хэрхэвч хүлээж чадахгүй хэмээсэнд, Дээд хурлын газраас дахин эгүүлэн ирсэн нь, одоо танай Доод хурал Дундад Иргэн Улсад дагахгүй хэмээсэн нь, нэн нийлэлцэхгүй, аливаад ер цагийг дагаж, хүчирхэг буурайн байдалд нийлүүлэхгүй болбаас яахин болох болой. Бас байлдаан үүсгэвээс цөөхнөөр олныг дийлэн чадахгүйд хүрч зовлон үлэмж болно. Харин дуугүй дагах нь Богд хаан болон ноёд түшмэд олон ардад хүртэл эрх завшаан болох зүйл бүхий болой.” (9.37) Үүнээс үзэхэд Дээд хурлын бодлого маш тодорхой байсан боловч Хүрээнд дээдсүүдээс тараасан тусгаар тогнолоо худалдлаа гэсэн цуу яриа Доод хурлынханд нилээд хүчтэй нөлөөлжээ гэж үзмээр байна. Улсын Дээд, Доод хурлаас улс орны тусгаар тогтнол, монгол улсаа эрчимтэй хөгжүүлэх талаарх хуралдаж хэлэлцэж байсан баримтуудаас харахад 1914 онд Монголд парламентийн засаглалын эх үндэс буюу ардчилсан ёсны эхлэл тавигдаж байжээ гэмээр санагдана. Ардчилсан ёс 1911 оноос эхэлсэн үү гэсэн асуудлыг нээлттэй үлдээе.

Abstract

The author tried to change the understanding that after the National Freedom Movement of 1911 feudalism remained unchanged, no reform was made in the political, economic and social life of the country except some minor insignificant measures, and particularly aimed to remind that it is the time to determine if the establishment of Upper and Lower Khurals, with the right to give advice to the absolute monarchy of Mongolia, was the start of democracy.

Ном зүй

1. Р.Болд, Монголын тусгаар тогтнолын талаарх Америкийн үзэл, хандлага, байр суурь, 1910-1973, диссертаци, 2006 он.
2. Монгол Улсын түүх. УБ. 2006 он
3. Монгол төрийн сэцэн билэгт зүтгэлтэн. УБ.2006 он
4. Музей судлал. УБ.2003 он
5. С.Отгонжаргал. XX зууны Монголын түүхийг шинээр эргэн харахуй. (1921-1990). УБ.2003 он
6. Монгол улсын дээд, доод хурал. Баримт бичгийн эмхтгэл. I. (1914-1916). УБ. 2003 он
7. Ц.Пунцагноров. Монголын автономит үеийн түүх. УБ.1955 он
8. Н.Магсаржав. “Монгол Улсын шинэ түүх” УБ.1994 он
9. МАХН-ын түүхэнд холбогдол бүхий зүйлүүд. УБ.2004 он